



208

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 05 сарын 13 өдөр


Дугаар 177

Улаанбаатар хот

Г Мэс заслын тусlamж, үйлчилгээнд
хяналтын хуудас нэвтрүүлэх тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйл, Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, мэс заслын тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь.

1. “Мэс заслын хяналтын хуудас хөтлөх журам”-ыг нэгдүгээр, “Мэс заслын хяналтын хуудас”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. “Мэс заслын хяналтын хуудас”-ыг мэс заслын тусlamж, үйлчилгээнд мөрдүүлж хэвшүүлэхийг тусгай мэргэжлийн төв, төв эмнэлэг, амаржих газар, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, мэс заслын тасаг нэгжтэй эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Мөнхбат), мэс заслын мэргэжлийн салбар зөвлөл (Н.Баасанжав)-д даалгасугай.
4. Тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэхийг Бодлого төлөвлөлтийн газар (Ц.Цолмонгэрэл), Санхүү, эдийн засгийн хэлтэс (Д.Дамдиндорж), тусгай мэргэжлийн төв, төв эмнэлэг, амаржих газар, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, мэс заслын тасаг нэгжтэй эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.



002138

МЭС ЗАСЛЫН ХЯНАЛТЫН ХУУДСЫГ ХӨТЛӨХ ЖУРАМ

Мэс заслын тасаг, мэс заслын нэгдсэн тасагтай эмнэлэг бүр өөрсдийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мэс заслын хяналтын хуудсыг мөрдсөнөөр олон тооны хүндрэлээс зайлсхийх боломжтой.

1. Мэс заслын хяналтын хуудсыг хөтлөхөд тавигдах ерөнхий шаардлага

1. Мэс засал хийх биеийн хэсэгт тэмдэглэгээ хийх арьсны харандаа (skin marker), метрийн шугам, рентген үл нэвтрэх утастай цагаан материал хэрэглэнэ.
2. Өөрийн дотоод нөөц, зохион байгуулалтад тулгуурлан мэс заслын хэсэгт "хяналтын сувилагч", мэс заслын нэг оронд 2 сувилагч ажиллуулна.
3. Эмнэлгийн нэг удаагийн хэрэглээний хэрэгслийг ашиглана.
4. Мэс засал эхлэхийн өмнө аппарат, тоног төхөөрөмжийн инженер, техникчийн аль нэг нь мэс засалд хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгаж, зөвшөөрөл олгосон байна.

2. Мэс заслын хяналтын хуудсыг хөтлөх ерөнхий зарчим

1. Мэс заслын хуудсыг багаар хамтран бөглөнө.
2. Алхам бүрийг чанга дуугаар асууж, баталгаажуулна.
3. Эдгээр хяналтын хуудасны хэрэгжилтэд тасгийн эрхлэгч, ахлах сувилагч, сувилгааны алба, чанарын алба хяналт тавьж, үр дүнг сар бүр тооцож, холбогдох арга хэмжээг авна.

3. Мэс заслын хяналтын хуудсыг дараах зааврын дагуу шалгаж хөтөлнө.

3.1 Мэс заслын аюулгүй байдлыг бүртгэх хяналтын хуудас

- Мэс заслын өмнө, явцад, дараа гарч болзошгүй хүндрэлээс сэргийлнэ.
- Зайлсхийх боломжтой хүндрэлийг бууруулна.
- Мэс заслын багаар ажиллах, алхмуудыг мөрдөж, дадал болгоно.

1. Мэс заслын аюулгүй байдлыг бүртгэх хуудасны нэгдүгээр хэсэг буюу мэдээгүйжүүлэг эхлэхийн өмнөх хяналтын хуудсыг мэдээгүйжүүлэгч эмч, мэс заслын хоёрдугаар сувилагч хамт бэлэн байдлыг шалгаж бөглөн, гарын үсэг зурна.
2. Мэс заслын аюулгүй байдлыг бүртгэх хуудасны хоёрдугаар хэсэг буюу арьсны зүслэг эхлэхийн өмнөх хяналтыг мэс заслын эмч, мэдээгүйжүүлэгч эмч, мэс заслын хоёрдугаар сувилагчийн хамт бэлэн байдлыг шалгаж бөглөн, гарын үсэг зурна.

3. Мэс заслын аюулгүй байдлыг бүртгэх хуудасны гуравдугаар хэсэг буюу мэс заслын өрөөнөөс гарахын өмнөх хяналтын хуудсыг мэдээгүйжүүлэгч эмч, мэс заслын эмч, мэс заслын сувилагчдын хамт шалгаж бөглөн, гарын үсэг зурна.
4. Мэс заслын аюулгүй байдлыг бүртгэх хуудас нь 2 хувь байна. Эх хувийг өвчний түүхэнд хавсаргаж, 2 дахь хувийг мэс заслын хэсэгт үлдээн, судалгаанд хэрэглэх ба үнэлгээ хийнэ.

3.2 Мэс заслын сувилагчийн хяналтын хуудас

- Гадны биетийг үлдээхээс сэргийлнэ.
 - Нян судлалын болон эдийн шинжилгээг солих, хаяхаас сэргийлнэ.
1. Мэс заслын хоёрдугаар сувилагч мэс заслын өмнө, дунд ба төгсгөлд хяналтын хуудсыг бөглөж гарын үсэг зурна.
 2. Мэс засал дууссаны дараа мэс заслын нэгдүгээр туслах эмч хянаж, гарын үсэг зурна.
 3. Мэс заслын сувилагчийн хяналтын хуудас нь 2 хувь байна. Эх хувийг өвчний түүхэнд хавсаргаж, 2 дахь хувийг хагалгааны хэсэгт үлдээн, судалгаанд хэрэглэх ба үнэлгээ хийнэ.

3.3 Мэдээгүйжүүлгийн зарлагын хяналтын хуудас

- Мансууруулах сэтгэц, нөлөөт эмийн зарлага, хяналтыг сайжруулна.
 - Устгал хийсэн тэмдэглэлийг баталгаажуулна.
1. Мэдээгүйжүүлгийн сувилагч мэс заслын явцад хэрэглэгдсэн эм тарианы тунгийн хэмжээг бичиж тэмдэглэнэ.
 2. Үлдэгдэл эм тарианы устгалыг бичиж, бүртгэнэ.
 3. Мэдээгүйжүүлгийн эмч мэдээгүйжүүлгийн зарлагын хяналтын хуудсанд бичигдсэн эм тарианы зарцуулалт, устгалд хяналт тавьж гарын үсэг зурж, баталгаажуулна.
 4. Мэдээгүйжүүлгийн зарлагын хяналтын хуудас нь 2 хувь байна. Эх хувийг өвчний түүхэнд хавсаргаж, 2 дахь хувийг мэдээгүйжүүлгийн хэсэгт үлдээж, судалгаанд хэрэглэх ба үнэлгээ хийнэ.

3.4 Мэдээгүйжүүлгийн аппарат шалгах хяналтын хуудас

- Тоног төхөөрөмжийн эвдрэлээс гарах эрсдлийг бууруулна.
- Мэдээгүйжүүлгийн аппаратын бэлэн байдлыг хангана.
 1. Өглөө ажил эхлэхийн өмнө инженер (техник), мэдээгүйжүүлгийн эмч, сувилагч нар шалгаж, тэмдэглэл хөтөлнө. Дутуу байгаа зүйлсийн талаар мэдээгүйжүүлэг эхлэхээс өмнө эмч, тасгийн эрхлэгчид мэдээлнэ.

2. Мэс засал бүрийн өмнө гэсэн заалтыг мэдээгүйжүүлгийн эмч, сувилагч шалгаж тэмдэглэнэ.
3. Мэдээгүйжүүлгийн аппарат шалгах хяналтын хуудас нь нэг хувь байх бөгөөд өвчний түүхэнд хавсрагдахгүй, мэдээгүйжүүлгийн хэсэгт хадгалагдана.

3.5 Амбулаторт хийгдэх мэс ажилбарын хяналтын хуудас

- Амбулаторт хийгдэх мэс ажилбарын чанар, аюулгүй ажиллагааг нэмэгдүүлнэ.
- Амбулаторт хийгдэх мэс ажилбарын хүндрэлээс сэргийлнэ.
 1. Амбулаторт хийгдэх мэс ажилбарын хяналтын хуудсыг мэс заслын эмч бөглөнө.
 2. Үйлчлүүлэгчийн амин үзүүлэлтийг боолтын сувилагч мэс ажилбарын өмнө ба дараа үзэж тэмдэглэнэ.
 3. Амин үзүүлэлт хэлбэлзэлтэй тохиолдолд эмчид заавал мэдэгдэнэ.
 4. Амбулаторт хийгдэх мэс ажилбарын хяналтын хуудас нь 2 хувь байна. Эх хувийг амбулаториор эмчлүүлэгчдийн картанд хавсаргаж, 2 дахь хувийг боолтын кабинетэд үлдээж, судалгаанд хэрэглэх ба үнэлгээ хийнэ.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
177 тушаалын хоёрдугаар хавсралт

МЭС ЗАСЛЫН АЮУЛГҮЙ

Мэдээгүйжүүлэг эхлэхийн өмнө

Мэдээгүйжүүлэгч эмч,
сувилагчийн хамт шалгана.

Өвчтөний овог нэр, хийгдэх
ажилбарын талаар өөрөөс нь
асууж баталгаажуулах

Тийм

Зүслэг хийх талбай
тэмдэглэгдсэн эсэх

Тийм

Шаардлагагүй

Мэдээгүйжүүлгийн аппарат
ажиллаж байгаа болон эм
ария бүрэн эсэх

Тийм

Үгүй

Өвчтөнд пульсоксиметрийн
хяналт хийх, ажиллаж байгаа
эсэх

Тийм

Үгүй

Өвчтөнд мэдэгдсэн харшил
байгаа эсэх

Тийм

Үгүй

Амьсгалын зам чөлөөлөхөд
төвөгтэй байдал болон
бөглөрлийн эрсдэл байгаа
эсэх

Тийм /багаж төхөөрөмж
болон тусламж үзүүлэх
боломжтой /

Үгүй

Цус алдах эрсдэл /500 мл
дээш, хүүхдэд 7 мл/кг/

Тийм /төвийн эсвэл
захад хоёр судсанд уян
зүү тавьсан/

Үгүй

Гарын үсэг

..... /



Тайлбар: Зөв бол ✓ тэмдэглэнэ.

БАЙДЛЫГ БҮРТГЭХ

Арьсны зүслэг эхлэхийн өмнө

Мэс заслын эмч,
мэдээгүйжүүлэгч эмч,
сувилагчдын хамт шалгана.

- Тухайн багийн гишүүд
өөрсдийн нэр, үүргийг
танилцуулсан
- Өвчтөний нэр, хийгдэх
мэс засал, зүслэгийн
хэсгийг баталгаажуулан
шалгасан

**Сүүлийн 60 минут дотор
антибиотикийн урьдчилан
сэргийлэлт хийгдсэн эсэх**

- Тийм
- Шаардлагагүй

Гарч болох хүндрэлүүд

Мэс заслын талаас

- Гарч болох гэнэтийн
хүндрэл байгаа эсэх
- Хагалгаа хэр удаан
үргэлжлэх
- Хэр зэрэг цус алдах

Мэдээгүйжүүлгийн талаас

- Тухайн өвчтөнд
мэдээгүйжүүлэгтэй
холбоотой өвөрмөц
онцлог байгаа эсэх

Сувилагчийн талаас

- Багажинд ариутгал бүрэн
хийгдсэн эсэх
/ариутгалын үр дүнг
индикаторын өнгөөр
шалгах/
- Багаж, төхөөрөмжинд
ямар нэгэн анхаарах
асудал байгаа эсэх

**Өвчтөний шаардлагатай
шинжилгээнүүдийг /рентген,
КТ, MRI/ байрлуулсан эсэх**

- Тийм
- Шаардлагагүй

Гарын үсэг

..... /

..

ХЯНАЛТЫН ХУУДАС №01

Мэс заслын өрөөнөөс гарахын өмнө

**Мэдээгүйжүүлэгч эмч, мэс
заслын эмч, хагалгааны
сувилагчдын хамт шалгана.**

**Сувилагч доорх
мэдээллүүдийг
баталгаажуулах**

Хийгдсэн мэс заслын нэр

.....

Багаж, бөмбөлөг,
самбай, зүү зэргийн тоо
тохирч байгаа эсэх

Шинжилгээнд өгөх сорьц,
хаяг, өвчтөний нэр
тохирч байгаа эсэх
/ тод чангаар дуудаж
тулгах /

Багаж, төхөөрөмжийн
эвдрэл байсан эсэх

**Мэс заслын эмч
мэдээгүйжүүлэгч эмч,
сувилагч нар:**

Өвчтөний цаашдын
эмчилгээний
менежментийн талаар
ярилцсан эсэх

Өвчтөн сэрэх үед болон
эмчилгээнд анхаарах
зүйлс байгаа эсэх

Эмч, сувилагчийн эрсдэл

- Зүү, хурц үзүүртэй зүйлд
хатгагдсан
- Бээлий цоорсон
- Түлэгч аппаратад
түлэгдсэн
- Нүд рүү шингэн, цус
үсэрсэн


Авсан арга хэмжээ

.....

Гарынүсэг

..... /

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
17. тушаалын хоёрдугаар хавсралт

Овог		МЭС ЗАСЛЫН СУВИЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС № 02 (а)						
Нэр		20... он сар өдөр		<input type="checkbox"/> Төлөвлөгөөт <input type="checkbox"/> Яаралтай		Тэмдэглэгээ : <input type="checkbox"/> хүснэгтэнд ✓ -аар тэмдэглэнэ		
Регистрийн дугаар		Өвчний түүх №		Мэс заслын зөвшөөрөл		Ухаан санааны байдлыг үнэлж нь: <input type="checkbox"/> хэвийн <input type="checkbox"/> унтаа <input type="checkbox"/> ком		
Хяналт хийсэн сувилагчийн нэр		Мэс заслын өрөөний №		<input type="checkbox"/> тийм <input type="checkbox"/> үгүй				
№	Багийн эмч нар		Цаг	Багийн сувилагч нар		Цаг		
1		Мэс заслын эмч				1-р сувилагч		
2		1-р туслах эмч				2-р сувилагч		
3		2-р туслах эмч				Мэдээгүйжүүлгийн сувилагч		
4		Мэдээгүйжүүлэгч эмч				Сэргээх өрөөний сувилагч		
5						Үйлчлэгч		
6								
Мэс заслын онош				Өвчтөний байрлал:				
Мэс заслын явцад гарсан хүндрэл:				<input type="checkbox"/> хэвтээ <input type="checkbox"/> түрүүлгээ <input type="checkbox"/> хөл өргөсөн <input type="checkbox"/> толгой өргөсөн <input type="checkbox"/> баруун хажуу <input type="checkbox"/> зүүн хажуу <input type="checkbox"/> сугаа <input type="checkbox"/> бусад				
Цус алдсан								
Мэс заслын дараах онош								
Мэдээгүйжүүлгийн төрөл <input type="checkbox"/> перөнхий <input type="checkbox"/> борчны <input type="checkbox"/> охориг <input type="checkbox"/> охэсгийн			Хүндрэл гарсан эсэх <input type="checkbox"/> отийм <input type="checkbox"/> үүгүй		Мэс заслын дараах өвчтөний байдал <input type="checkbox"/> сэргээх <input type="checkbox"/> хэвэндээс орсон <input type="checkbox"/> ЭЭТ <input type="checkbox"/> ердийн тасаг <input type="checkbox"/> гартээ			
Өвчтөн ирсэн цаг	Мэдээгүйжүүлэг <input type="checkbox"/> эхэлсэн цаг	Мэс засал <input type="checkbox"/> эхэлсэн цаг	Хэвлэлийн хаасан цаг		Арьс <input type="checkbox"/> оёсон цаг	Мэс засал <input type="checkbox"/> дууссан цаг	Мэдээгүйжүүлэг <input type="checkbox"/> дууссан цаг	Өвчтөн гарсан цаг
Арьсны халдвартай хийх хэсэг (— улаан балаар) <input type="checkbox"/> 7,5% медин <input type="checkbox"/> 10% тамедин <input type="checkbox"/> 0,5% перкись <input type="checkbox"/> 0,05% хлоргексидин <input type="checkbox"/> 3% тамедин <input type="checkbox"/> бусад ()								
Арьсанд зүслэг хийх хэсэг (— улаан балаар) <input type="checkbox"/> тэмдэглэх Түлэх T Y (тэмдэглэхΔ) Зүслэг хийх T Y (тэмдэглэхWW) Судсанд гуурс тавих T Y(тэмдэглэх x) Халаагч гудас T Y(тэмдэглэх o) Чангалуур T Y (тэмдэглэх■)								
Чангалуур	Баруун	Зүүн						
Эхэлсэн цаг								
Дууссан цаг								
Даралт								
Мэс заслын өмнөх бэлтгэл			<input type="checkbox"/> Өвчтөнөө зөв байрлуулсан <input type="checkbox"/> Мэс заслын талбайг ариутгах <input type="checkbox"/> Электрод наасан <input type="checkbox"/> Өвчтөнөө хучсан <input type="checkbox"/> Катетр <input type="checkbox"/> Чангалуур хэрэглэсэн <input type="checkbox"/> хаймсуур					
Биеийн хэсэг	Мэс заслын өмнөх	Мэс заслын дараах	Тайлбар	Нэр	Хэмжээ	Тоо	Төрөл	
Ахар сүүл	X U C H	X U C H						
Дал	X U C H	X U C H						
	X U C H	X U C H						
	X U C H	X U C H						
	X U C H	X U C H						
Гарын усэг								
X-хэвийн	Y- улайсан	Ц- цэврүүтсэн	Ш- шархалсан	Х, У, Ц, Ш -"Х"-р тэмдэглэнэ				

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
177 тушаалын хоёрдугаар хавсралт

МЭС ЗАСЛЫН СУВИЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС № 02(б)

Мэс засалд хэрэглэгдсэн багаж, материалын тоо						Нян судлал, эдийн шинжилгээ									
Төрөл	Мэс заслын өмнө		Нэмэгдсэн		Мэс заслын дараа		Эдийн нэр	Эмч	Сувилагч	Тайлбар					
	Тоо хэмжээ	Лав лах	Тоо хэмжээ	Лав лах	Тоо хэмжээ	Лав лах									
Бөмбөлөг															
Самбай															
Багаж төхөөрөмж															
Гарын үсэг	Мэс заслын 1-р сувилагч						Материалын нэр	Буртгэл	Буртгэл	Нэмэгдсэн					
	Мэс заслын 2-р сувилагч														
	Мэс заслын 1-р туслах эмч														
Материалын нэр	Буртгэл	Нэмэгдсэн	Үнэл гээ	Материалын нэр		Буртгэл	Нэмэгдсэн	Үнэл гээ	Материалын нэр						
Ирт 96%				Ариун бээлий					Перкись водород 3%						
Тамедин 7,5%				Үзлэгийн бээлий					Сексисефт 2%						
Тамедин 2,5%				Хутганы ир					Сексисефт 0,5%						
Натри хлор 0,9%-400,0				Эм Ви Ар хутга					Алкохол 2%						
Натри хлор 0,9%-200,0				Кресцент хутга					Гексолкан 0,5%						
Натри хлор 0,9%-100,0				Кретом хутга					Хамрын O2 гуурс						
Натри хлор 0,9%-3л				Мэс заслын утас					Хэвлэлийн гуурс						
Рингер 0,5				Викрил утас					Хэвлэлийн гуурс вакумтай						
Нэрмэл 0,5				Силк зүүтэй					Фолей гуурс						
Новокайн 0,5%-100,0				Силк зүүгүй					Джей /J stent/ гуурс						
Алкайн 1%				Пролейн 1-0					Давсагны гуурс						
Адерналин 1,0				Пролейн жонсон					Бөөрний сувгийн катетр						
Дексаметазон 1,0				Кетгут					Резескопийн электрод						
Лидокайн 2%-2,0				Нейлон					Маликот гуурс						
Экстрикамерил пилокарпин 10%-0,1				Дурангийн клип					Сувгийн чиглүүлэгч /Guide wire/						
Экстрикамерил эпинитран 10%-0,2				Шархны үдээс					Дреп наадаг бүтээлэг						
Нтамицин 2,0				Шархны наалт					Хэвлэлийн хальс						
Цефазолин 1,0				Шархны лент					Гипс						
Гидрокортизон суспенз				Самбай					Соруулгын гуурс хошуутай						
Ультравист				Бөмбөлөг					Тариур 20,0						
Урографин				Систем					Тариур 10,0						
Эмульс				Катжелл					Тариур 5,0						
Вискаэластик									Тариур 3,0						
Трипан блю 0,06%									Тариур 1,0						
Кассет пак /нүдний/									Нэг удаагийн зүү						
Метиллен хөх									Тулэгчийн хошуу						
1 удаагийн цаасан ком				1 удаагийн халад					Идэвхигүй электрод						
Тракор 1 аагийн				Верешийн зүү					Глицерин						
Мэс заслын 1-р сувилагч	Мэс заслын 2-р сувилагч						Хянасан 1-р туслах эмч								
Дууссан цаг															

Үргэлжилсэн цаг

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 177
тушаалын хоёрдугаар хавсралт

МЭДЭЭГҮЙЖҮҮЛГИЙН ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН ХУУДАС № 03

Өвчний түүхийн дугаар
Регистрийн дугаар
Овогнэрнасхүйс

--	--	--	--	--	--

20.....оны.....сарын.....өдөр

д/ д	Багаж хэрэгсэл	Нэг бүр үнэ	Хэрэгл эсэн хэмжээ	Нийт үнэ	д/д	Эм, тарианы нэрс	Нэг бүр үнэ	Хэрэглэ сэн хэмжээ	Нийт үнэ
1	Систем				1	Фентанил			
2	Уян зүү				2	Морфин			
3	З замтай крант				3	Тиопентал Na			
4	Тариур 50.0				4	Тракриум			
5	Тариур 20.0				5	Суксаметазон			
6	Тариур 10.0				6	Изофлуран			
7	Тариур 5.0				7	Глатон			
8	Тариур 3.0				8	Кетамин			
9	Сул зүү				9	Пропофол			
10	Цагаан хоолойн гуурс Амьсгалын хүрээ				10	Эфедрин			
11	Нянгийн шүүлтүүр				11	Седуксен			
12	Соруулгын гуурс				12	Анальгин			
13	Амьсгалын зам чөлөөлөгч				13	Атропин			
14	Электрод				14	Прозерин			
15	Сул бээлий				15	Адерналин			
16	Ариун бээлий				16	Глюкоз 40%			
17	Нугасны зүү				17	Лидокайн			
18	Пертурааль гуурс				18	Бупивакайн 0.5%-20.0			
19	Давсагны гуурс				19	Бупивакайн 0.5%-4.0			
20	Шээсний уут				20	Натри хлор 0.9%-400.0			
21	Ходоодны зонд				21	Рингер			
22	Адсорбер				22	Хүчил терөгч			
23	Бинт				23	Спирт 76%			
24	Шарик				24	Тамедин 7.5%			
25	Наалт				25				
26					26				

Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн зарцуулалт

Эмийн нэр	Хэрэглэсэн тун	Серийн дугаар	Үлдэгдэл	Сувилагч	Эмч
1					
2					
3					
4					
5					
6					

Устгал хийсэн тэмдэглэл

Эмийн нэр	Үлдэгдэл тун	Серийн дугаар	Сувилагч	Эмч
1				
2				
3				
4				
5				

Нийт үнийн дүн
Мэдээгүйжүүлгийн эмч / / Сувилагч / /

Эрүүл мэндийн сайдын 2013 оны
177 тушаалын хоёрдугаар хавсралт

МЭДЭЭГҮЙЖУУЛГИЙН АППАРАТ ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС №04

(ажил эхлэхийн өмнө) он сар өдөр

1	ар амьсгалуур (амбу) бэлэн, ажиллагаа нь хэвийн байх	<input type="checkbox"/>
2	Машини автомат ажиллагааг үйлдвэрлэгчийн зааврын дагуу шалгах	<input type="checkbox"/>
3	Цахилгаан хангамж:	
	Цахилгаанд холбоно	<input type="checkbox"/>
	Асаах товчлуурыг залгана	<input type="checkbox"/>
	Машиныг цахилгаанаас түр салган батерейн цэнэг хэдэн % байгааг шалгана	<input type="checkbox"/>
4	Хийн хангамж, соруулга:	
	Хийн хангамж ба вакуум холболтыг "угсарч-дугтрах сорил" –оор шалгана	<input type="checkbox"/>
	Хийн даралт хэмжигчийн заалт ногоон буст байгаа эсэхийг (400-500 кРа) харна	<input type="checkbox"/>
	Ургал хэмжигчийг хөвүүр бөмбөлөгийн хөдөлгөөнөөр шалгана	<input type="checkbox"/>
	Цусан дахь хүчилтөрөгчийг хянах дохиоллын ажиллагаа (O ₂ мэдрэгч, N ₂ O/O ₂ - закись азот хэрэглэх үе	<input type="checkbox"/>
	O ₂ үлээх товчлуурыг дарж O ₂ -р үлээх ажиллагааг шалгана	<input type="checkbox"/>
	Соруулгыг шалгаж бэлтгэнэ	<input type="checkbox"/>
5	Амьсгалын хүрээ:	
	Амьсгалын хүрээний битүүмж "Уут базах" сорилоор* шалгана	<input type="checkbox"/>
	Илүүдлийн (хэт даралтын) хавхлагын ажиллагааг шалгана	<input type="checkbox"/>
	Ууршуулагч зөв угсрагдсан, зөв бодисоор дүүргэгдсэн	<input type="checkbox"/>
	CO ₂ -н абсорбер (дүүргэлт, өнгөний өөрчлөлт, норсон эсэх) шалгана	<input type="checkbox"/>
	Холимог хийн гаралтын холболт зөв эсэхийг хянах	<input type="checkbox"/>
6	Амьсгалын аппарат:	
	Хөөрөг шахаж амьсгалын хүрээнд даралт нэмэгдэхийг сорино	<input type="checkbox"/>
	Амьсгалын аппаратын үзүүлэлтийн дохиоллын хязгаарыг тохируулна	<input type="checkbox"/>
7	Гадагшлуулагч:	
	Идэвхигүй аргаар бол өрөөнөөс гадагшлуулалтыг харна	<input type="checkbox"/>
	Идэвхитэй системд холболтыг шалган, сорох хурдыг шалгана	<input type="checkbox"/>
8	Хяналтын монитор:	
	Хяналтын мониторыг асаан дохиоллын хязгаарыг тохируулна	<input type="checkbox"/>

Мэс засал бурийн өмнө:

	1	2	3	4	5
1	Гар амьсгалуурыг бэлэн байлгах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Амьсгалын хүрээ, шүүлтуүрийг угсран бүрэн байдлыг шалгах	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Ууршуулагчийг зөв бодисоор дүүргэсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Битүүмжийг "Уут базах" сорилоор шалгаж даралт үүсгэн нэг чигийн хавхлагийн ажиллагаа, ууршуулагчийг нээлттэй, хаалттай үед хий алдаж буй эсэхийг шалгана	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Амьсгалын аппаратын хэвийн ажиллагааг шалган илүүдэл даралт гаргах хавхлаг ажиллаж байгааг нягтална	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Амьсгалын зам чөлөөлөх хэрэгслийг бэлтгэнэ	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Соруулгын ажиллагааг шалгаж бэлдэнэ	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

* Уут базах сорил: Бүх хийн ургалыг хааж илүүдэл хий гаргах хавхлагыг 30-д тохируулаад Y-хэсгийг таглан O₂ үлээх товчлуурыг даран уутыг дүүргэхэд 10 секунд уутан дахь хий алдагдахгүй байх ба уутыг базлахад нэг чигийн хавхлагууд дээш доош хөдөлнө.

Жиц: Өглөө бүр дээрх зааврын дагуу аппаратыг шалгаж дэвтэрт тэмдэглэл хөтлөн техникч, сувилагч гарын үсэг зурж баталгаажуулна. Мэдээгүйжүүлэгч эмч аппарат хэрэглэсэн тохиолдол бүртээ Амбу, хийн ерөнхий гаралт, төвөтгэй интубаци болон сэхээн амьдруулах иж бүрдэлийн бэлэн байдлыг шалгаж мэдээгүйжүүлгийн картад тэмдэглэнэ.

217
Эрүүл мэндийн сайдын 2013 оны
тушаалын хоёрдугаар хавсралт

АМБУЛАТОРТ ХИЙГДЭХ МЭС АЖИЛБАРЫН ХЯНАЛТЫН ХУУДАС №05

Дугаар №

Эмнэлгийн нэр

Тасаг, кабинетийн нэр

Овог..... Нэр..... нас..... хүйс.....

Регистерийн дугаар

Тогтмол хаяг:

Ажлын газар:

Эмчид үзүүлсэн он..... сар..... өдөр

Өвчин эхэлсэн он..... сар..... өдөр

Явуулсан эмнэлэг:

Мэс ажилбар хийх үндэслэл /Онош/

Мэс ажилбарын өмнө	Мэс ажилбарын дараа
Даралт.....	Даралт.....
Судасны лугшилт.....	Судасны лугшилт.....
Амьсгал.....	Амьсгал.....

Мэс ажилбар хийхийг зөвшөөрсөн эмчлүүлэгчийн гарын үсэг

Мэдээгүйжүүлгийн хэлбэр:

Мэс ажилбар эхэлсэн цаг..... мин Дууссан цаг мин

Мэс ажилбар хийсэн нийт хугацаа цаг..... мин

Мэс ажилбарын тэмдэглэл:

Үйлчлүүлэгчид өгсөн зөвлөгөө:

1.

2.

3.

4.

Мэс ажилбар хийсэн эмч /..... /

Тусласан эмч /..... /

Боолтын сувилагч /..... /

Жич: Эмч хувийн тамга дарна.